



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 0173

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.21 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Наадамчдын зам дагуу таригдсан том оврын шилмүүст модыг гэрэлтүүлэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Энэ тушаалын 1 дүгээр зүйлд заасан ажлуудын худалдан авах ажиллагааг хууль журамд нийцүүлэн зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Хэрлэн/-нд даалгасугай.

3. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж хяналт тавьж ажиллахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Г.Хэрлэн/-т, гүйцэтгэлийг актаар хүлээн авахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/49 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг /Ц.Рэгзэдмаа/-т тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  А.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 03 дугаар сарын 20 өдрийн  
..... 173 ..... тушаалын ..... хавсралт



## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, Санхүүгийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Б.Отгонбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	А.Нямдорж	Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн ТББ /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн